



БАТЛАВ  
ДЭД ДАГГА, ОНЦГОЙ БАЙДЛЫН  
ХУРАНДАА Т.АРИУНБУЯН

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР, ХЭЛТСИЙН ГАЛ ТҮЙМЭР  
УНТРААХ АВРАХ АНГИ, НИЙСЛЭЛИЙН АВРАХ АНГИ, САЛБАР, АВРАХ БҮЛГҮҮДЭД  
ЗОХИОН ЯВУУЛАХ “ОЙ, ХЭЭРИЙН ГАЛ ТҮЙМЭРТЭЙ ТЭМЦЭХ ТЕХНИК, БАГАЖ  
ХЭРЭГСЭЛ, АЛБА ХААГЧДЫН БЭЛТГЭЛ, БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГУУЛАХ”  
НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖ

Нэг: Зорилго.

Зорилго: Аймаг, нийслэлийн онцгой байдлын газар, хэлтэс, гал түймэр унтраах, аврах анги, аврах тусгай анги, аврах бүлгийн алба хаагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, ой, хээрийн түймэр унтраах багаж хэрэгсэл, автомашин, техникийн бэлтгэл, бэлэн байдлыг дээшлүүлэх, ашиглалтын аюулгүй ажиллагааг хангуулахад чиглэгдэнэ.

Хоёр: Нэгдсэн арга хэмжээ явуулах хугацаа

“Ой, хээрийн гал түймэртэй тэмцэх техник, багаж хэрэгсэл, албан хаагчдын бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах” нэгдсэн арга хэмжээг 2016 оны 03 дугаар сарын 07-ны өдрөөс 03 дугаар сарын 21-ний өдрийг хүртэл хугацаанд зохион явуулна.

Гурав: Ажлын чиглэл.

Аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтсийн Гал түймэр унтраах, аврах анги, Аврах тусгай анги, бүлгүүд удирдамжийн хүрээнд дараах чиглэлийн арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Алба хаагчдад хууль эрх зүйн болон гал унтраах дүрэм, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм, ой, хээрийн гал түймэр унтраах арга зүй, байр зүйн зураг дээр ажиллах, шаардлагатай тохиолдолд өөрийгөө болон бусдыг аврах анхан шатны мэдлэг олгох чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран 2-оос доошгүй удаа сургалт зохион байгуулах.
2. Яаралтай цугларах дохиогоор бие бүрэлдэхүүнийг ажиллуулж 5 км-ын зайнд аяны алхаагаар аялуулж тодорхой цэгт аранзны бэлэн байдлыг шалгаж, алба хаагчдын бие бялдарыг хөгжүүлэх зорилгоор уралдаан тэмцээн зохион байгуулах.

*Жич: Аранзанд утаа, салхи, шорооноос харах эрхтэнийг хамгаалсан битүүмжлэл сайтай нүдний шил, 4-5 удаа солих даавуун оймсыг зайлшгүй байлгах.*

3. Ой, хээрийн гал түймэр унтраах автомашин, техник, багаж хэрэгслийн аюулгүй ажиллагааг хангах, засвар, үйлчилгээг хийж, шаардлагатай сэлбэг, хэрэгсэл, шатахууныг нөөцөлж албаны бэлтгэл, бэлэн байдлыг хангах.
4. Алба хаагч нэг бүрийн гал түймэр унтраах гар багаж хэрэгслийн бэлэн байдлыг шалгаж шаардлагатай тохиолдолд ашиглах, нөхөн хангах зорилгоор гар багаж хэрэгслийн нөөцийг бүрдүүлж, багаж тус бүрээр судалгааг гаргах.

5. Ой, хээрийн гал түймэр унтраах үед үлээгч аппараттай удаан хугацаагаар ажиллаж байгаа алба хаагчдын бие эрхтэнийг хамгаалах зорилгоор галд тэсвэрлэн шатдаг материалаар энгэр болон бүсэлхий орчмыг хамгаалсан хормогчыг өөрсдийн дотоод нөөц бололцоог ашиглан 15 ширхэгээс доошгүйг хийж бэлтгэх.

*Жич: Үлээгч аппаратын салхины эрч гаргах хүчин чадлаас хамаарч олон цаг ажилласан алба хаагчын давсаг, бүсэлхий орчим халуун агаараар халалт өгч байгаа тул алба хаагчдын эрүүл мэндийг хамгаалах зорилготой.*

6. Ой, хээрийн түймрийн дуудлагаар шуурхай цугларах төлөвлөгөөг тодотгох, бэлтгэл ээлжийн алба хаагчдын холбоо мэдээллийн бүртгэл хөтлөх, бэлэн байдлыг хангах.

Дөрөв: Тайлан, мэдээнд тавигдах шаардлага.

1. Нэгдсэн арга хэмжээний хүрээнд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө гарган газар, хэлтэс, ангийн даргаар батлуулж, төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэсэн ажлын үр дүнг тооцож гүйцэтгэлийн тайланг баталгаажуулсан байна.
2. Офицер, ахлагч нараас шүүлэг авч ирц, үнэлгээг тайланд тусгах, сургалт зохион байгуулсан талаарх илтгэх хуудас, гэрэл зургаар баримтжуулах.
3. Аранзны үзлэгээр заагдсан зүйлсийг жигдрүүлж, спорт уралдаан тэмцээн зохион байгуулсан тухай гэрэл зургаар баримтжуулж тайланд хавсаргах.
4. Ой, хээрийн түймэр унтраах техник, багаж хэрэгсэлд үзлэг, шалгалт явуулж одоо байгаа болон шинээр хийсэн гар багаж хэрэгслийн судалгааг гарган гэрэл зургаар тайланд хавсаргах.
5. Алба хаагчдын эрүүл мэндийг хамгаалах болон гал түймэр унтраах үйл ажиллагааг хөнгөвчилсөн бүтээлч шинэ санааг хэрэгжүүлж фото зургаар баримтжуулж тайланд тусгах.
6. Удирдамжит нэгдсэн арга хэмжээний үр дүн, ололт амжилт, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх санал, дүгнэлт.

*Жич: Хэд, хэдэн гал түймэр унтраах, аврах ангитай газар, хэлтсүүд анги тус бүрээр үүрэг даалгавар өгч зохион байгуулна.*

Тав: Мэдээ тайлан ирүүлэх талаар.

Нэгдсэн арга хэмжээний хүрээнд зохион явуулсан ажлын тайланг 2016 оны 03 дугаар сарын 25-ны өдөр цахим хэлбэрээр [/gal\\_obeg@yahoo.com/](mailto:gal_obeg@yahoo.com) хаягаар, 03 дугаар сарын 28-ны өдрийн дотор Гал түймэртэй тэмцэх газарт албан бичгээр ирүүлсэн байна.

Зургаа: Дүгнэх талаар.

Нэгдсэн удирдамжит арга хэмжээний хүрээнд хийгдсэн ажлын тайланг хүлээн авч нэгтгэн үнэлгээ, дүгнэлт өгч Онцгой байдлын ерөнхий газрын дарга болон Гал түймэртэй тэмцэх газрын даргад танилцуулна.

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР